

**УНТЭ-ИЙН ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖИЙН АЛБАНД ХАЛААЛТ,
АГААР СЭЛГЭЛТИЙН ИНЖЕНЕРИЙН АЖЛЫН БАЙРНЫ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА.**

Гүйцэтгэх үүрэг:

- ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээг хэвийн явуулах орчин бүрдүүлэх, байгууллагын халаалт, агаар сэлгэлт, хөргөлт ба кондиционерын системийн зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж техник технологийн зохион байгуулалт, ашиглалт, засвар үйлчилгээ, тохируулгыг хариуцан ажиллах;
- ✓ Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдээлэл хүргэх, мэргэжлийн арга зүйн зөвлөмж хүргэх;
- ✓ Эмнэлгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа чанар сайжруулах үйл ажиллагаанд оролцох;

Тавигдах шаардлага:

- ✓ Инженерийн боловсрол олгох их, дээд сургуулийг халаалт, агаар сэлгэлтийн инженер мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн;
- ✓ Мэргэжлийн чиглэлээр мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх;
- ✓ Мэргэжлээрээ 2-оос дээш жил ажилласан ажлын дадлага туршлагатай байх;
- ✓ Баримт бичиг боловсруулах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах, сургалт хийх ур чадвартай байх;
- ✓ Англи болон бусад гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байх;
- ✓ Компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадамжтай;

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн маягт
- Их дээд сургууль төгссөн дипломын хуулбар
- Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан бол гэрчилгээний хуулбарууд;
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Ажилд орохыг хүссэн өргөдөл

Дээрх шаардлагыг бүрэн хангасан материалыг УНТЭ-ийн 5-р давхар Захиргаа, хүний нөөцийн албанд 2026.08.20-ны өдрийн 15.00 дуустал хугацаанд хүлээн авна. Утас: 77111017

Сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион явуулна. Үүнд:

1. Баримт бичгийн шалгаруулалт
2. Сонгон шалгаруулалтын ярилцлага

УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба
2026.08.12